


# МАНСУУРЛААС ТА СЭРГИЙЛЖ ЧАДНА

Мэдээллийн багц-5



## **АРХИНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ НӨЛӨӨ, ГАРАХ АРГА ЗАМ**

### **▶ Архи үүссэн түүх**

Хүн төрөлхтөн архи анх хэрэглэж ирсэн буурал түүхийн эхлэлийг тогтоох бодит боломж бага юм. Гэвч анх ваар сав хийж ирсэн үетэй ойролцоо гэж үздэг нь үнэний хувьтай. Ваар саванд хадгалсан

элдэв жимс хадгалалтын явцад эсэж задраад бага хэмжээний спирттэй ундаа болсныг хүмүүс анх ууж эхэлсэн нь архи уух, түүнийг хэрэглэх эхлэл гэж судлаачид үздэг.

### **▶ Архины найрлага**

Архийг жимс, сүүг эсгэж нэрэх замаар гаргаж авдаг. Ингэж иссэн шингэн дэх сахар нь дрожжийн мөөгөнцөрүүдийн үйлчлэлийн дор спирт болон задардаг аж. Энэ исэлтийн явцад спиртээс гадна химийн олон төрлийн хортой бодис үүсдэг байна.

Архиар хордож амь насаа алдагсдад хийсэн задлан шинжилгээнээс үзэхэд хоол боловсруулах эрхтний салст бүрхэвч түлэгдэн ялзарч нэлэнхүйдээ өөхжин, бөөрний тахир сувгуудад эвэрлэг эсийн уургийн бүтцэд өөрчлөлт үүссэн байдаг.

### **▶ Архины нөлөө**

Архи нь цусанд шимэгдээд юуны түрүүнд тархинд нөлөөлж, мэдрэлийн эсийн тослог бодисуудыг уусган, уургийг бүлэгнүүлж исэлтийн процессыг алдагдуулна.


Эрдэмтдийн тооцоолсноор хүнд согтолтын үед мэдрэлийн 20 мянга хүртэл эс үхдэг байна. Бага ч гэсэн архи уухад тархины бор давхаргын саатлын процесс сулран “сэргэлэн цовоо” болж, зүрхний цохилт, хөдөлгөөн хурдасна.

Оюуны болон биеийн хүчний хөдөлмөрлөх чадвар буурч, хөдөлгөөний тэнцвэр алдагдана. Эрүүл үед байдаггүй хөнгөн хийсвэр, эсвэл нялуун, онгироо зан гаргаж, ямар ч хүмүүжилтэй хүн өөрийгөө барих чадвар, тавих хяналтаа бүрэн алдаж, ичиж зовохоо умартан хэнд юу ч хэлж, орчин тойрондоо ямар ч хор хөнөөл учруулж болзошгүй байдалд ордог.

Хэрэв архи үргэлжлүүлэн увал төв мэдрэлийн системийг хордуулах нь гүнзгийрч, тархины бор давхаргын сэрлийн процесс нь шавхагддаг тул бүх бие суларч ухаан балартан, гүн нойрсолтод орох ба амьсгал, зүрх судас зэрэг амьдралын чухал эрхтнүүдийн үйл ажиллагаа алдагдан, амьсгал зогсох, зүрх судасны гүн дутагдалд орж үхэх аюулд хүрдэг.

Мэдрэл сэтгэхүйн хүнд өвчин-архаг архичин болох нь ганц нэгхэн архидах явдлаас эхэлнэ. Үүнийг манай залуучууд, өсвөр үеийнхэн байнга анхаарч, санаж явах хэрэгтэй юм. Би байнга уух биш хааяа нэг балгалгүй яах вэ гэж өөрийгөө өөгшүүлэн даамжруулсаар, нэг л мэдэхэд архичин болохын үүд хаалганы бариулаас зуурчихсан байх явдал тохиолдоно.





АНУ-ын Массачусет муж улсын эмнэлгийн мэргэжилтнүүд доорх хэдэн шинжээр архи хэрэглэдэг хүн архичин болохын аль үед байгааг тодорхойлж болно гэж үзжээ. Үүнд:

- Нэг жилийн дотор 4 удаа согтотлоо уух
- Ажилдаа согтуу очих
- Ажил, үүргээ гүйцэтгэхийн тулд архи уух
- Согтуугаар машин жолоодох
- Согтуу үедээ гэмтэл авах
- Эрүүлдээ огт хийдэггүй зүйлээ согтуудаа үйлдэх



Эдгээр 6 шинжээс аль нэг нь байгаа бол “архичны босгыг” алхаад алмайрч зогссон, хоёр нь байгаа бол алхаж орчихоод үүдийг нь хаасан, гурав буюу түүнээс дээш тохиолдсон бол аль хэдийн хойморт нь суучихсан байна гэсэн үг.


### ► **Архи ба эмэгтэйчүүд**

Архичин эмэгтэйн зан чанар түргэн хугацаанд гүнзгий өөрчлөгдөх, цочромтгой, бүдүүлэг, хардах сэрдэх нь ихсэн гэр бүл, хамт олноосоо амархан хөндийрч тасардаг. Улмаар хүний ариун нандин цэвэр ичимтгий зан чанараа умартаж, зугаа цэнгэл хайн, архины хойноос улайран хөөцөлдөх нь эрэгтэйчүүдээс илүү хурц илэрдэг. Энэ байдал улам гүнзгийрвэл өмнөө тавих зорилгогүй, амьдралд сонирхолгүй болж уйдан, амиа хорлох эцсийн шийдвэрийг сонгох нь эмэгтэй архичдын дунд цөөн бус тохиолддог ажээ.

### ► **Эх эцгийн архидалт үр удамд нөлөөлөх нь**

ДЭМБ-ын мэдээгээр архинд нөлөөлдөггүй нэг ч эд эрхтэн, систем хүний биед байхгүй. Архи хүүхэд төрүүлэх үйл ажиллагаанд төдийгүй үр удамд хорт нөлөө үзүүлдэг тухай эрт дээр үеэс мэддэг байжээ. Архины хордлогоос ураг эхийн хэвлийд үхэх, архичин хүн үргүй болох, үрийн сувгийг нарийсган хатууруулах, үрийн шингэний ялгаралт багасах бэлгийн сулрал зэрэг сөрөг нөлөө үзүүлнэ.

Жирэмсэн үед зөвхөн 1 аяга шар айраг хэрэглэхэд улаан бөөмийн тоо цөөрч, эхийн умай дахь урагт хүчилтөрөгчийн архаг дутагдал үүсч үүний улмаас ургийн өсөлт удаашрах, эрхтэн системийн үйл ажиллагаа хямрах, ургийн тахины хүчилтөрөгч, цусан хангамж муудан



судасны ханын бэхжилт буурснаас төрөх үед тархинд цус шүүрэх, цус харвах, тархины даралт ихсэх зэрэг эмгэгтэй хүүхэд төрнө.

► **Архи хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндэд нөлөөлөх нь**

Уусан архи биед ороод хэдхэн минутын дараа тархинд хүрч нэвчин, цусанд дахь хэмжээнээсээ 70-75% хүртэл их болдог. Юуны түрүүнд тархины бор давхаргын эсүүд гэмтэнэ. Мэдрэлийн эсүүд дахин сэргэдэггүйгээрээ онцлог бөгөөд гүн гүнзгий гэмтээж, цаашид ой ухааны сулралд хүргэдэг.

Өчүүхэн хэмжээтэй архи хэрэглэхэд сэрэл саатлын процессын тэнцвэрийг алдагдуулж хүүхэд цочромтгой, тайван бус, амархан уйлдаг, уймраа, мартамхай болж хөдөлмөрийн чадвар буурна..

Багахан төдий архи ч уналт таталтын шалтгаан болж аажимдаа солиоролд хүргэх аюултай. Хүүхдийн зүрх судасны систем бага насанд маш хурдтай хөгжиж байх ба энэ үед зүрхний булчин цус, тунгалагаар их хангагддаг нь архинд маш мэдрэг болгодог. Архи цусны хүчилтөрөгчийн хангамжийг муутгаж, зүрхний булчингийн тэжээлийг доройтуулдаг.

Бэлгийн бойжилт эрчимтэй явагддаг 12-14 насанд хүүхдийн зүрх судасны системд үйл ажиллагааны хямрал үүсэж, зүрхний шуугиан сонсогдох, цусны даралт ихсэх зэрэг өөрчлөлт гарах боловч хөдөлмөр амралт хоолны дэглэмийг зөв зохицуулахад аяндаа арилдаг

Архи хоол боловсруулах эрхтэнд хүчтэй нөлөөлдөг. Архи байнга хэрэглэхэд ходоод гэдэс, элэг, нойр булчирхай

зэрэг эрхтэнүүд өвчилнө. Хүүхдийн гэдэс ходоодны замын эрхтэнүүдийн салст нимгэн, эмзэг, их нэвчимтгий байдаг нь архинд амархан гэмтэх шалтгаан болно.


Архи хамгийн хорт нөлөө үзүүлдэг эрхтэн бол элэг юм. Архичин хүмүүс нүүрс ус, хордлого эсэргүүцэх, уураг үүсгэх зэрэг элэгний ихэнх үйл ажиллагаанууд алдагддаг. Архи үргэлжлүүлэн уувал элэг өөхжих, үрэвсэн хатуурах зэрэг хүнд эмгэгт хүргэнэ.

## ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС ГЭЖ ЮУ ВЭ?



*Наркотик гэдэг нь “narkotikos” гэсэн мансуурах, мэгдэх, мансуурах гэсэн грек хэлнээс гаралтай үг бөгөөд мансуурахад хүргэдэг ургамлын болон синтетик үүсэл гаралтай янз бүрийн бодисын бүтэц бүхий бүлэг /зүйл/ хэрэглэгдэхүүн юм.*

Хар тамхи, мансууруулах бодис нь хүний уураг тархи, мэдрэл сэтгэхүйд хүчтэй хор нөлөө үзүүлдэг химийн бодис юм. Эдгээр бодисыг хэрэглэснээр эхний үед сэтгэн бодох хурд нэмэгдэж, сэтгэл хөөрлийн шинж түр зуур илэрч, удалгүй хөнгөн хэлбэрийн сэтгэл гутралын байдлаар солигдоно. Цааш сэтгэц, бие бялдрын эмгэг өөрчлөлт гарна. Ингэснээр уг бодисондоо дасч, үгүйлэн байж ядан, бүх бие нь янгинаж, уг бодисыг дахин хэрэглэхийн тулд юу ч хийхээс буцахгүй болгодог ба эрүүл хүний сэтгэц болон биед гүнзгий хортой нөлөө учруулдаг бодис юм.



## Хүний сэтгэцэд үйлчлэх байдлаар:

1. Төв мэдрэлийн системийг дарангуйлагч буюу оюуны идэвхийг сааруулах хэт тайвшруулах, нойрсуулах үйлчилгээтэй бодисууд
2. Төв мэдрэлийн системийг өдөөгч буюу сэтгэцийн идэвхийг сэргээж, сэтгэл санааг хий хөөрөл оруулах үйлчилгээтэй бодисууд
3. Солио үүсгэгч буюу хий юмс үзэгдүүлж, сонсогдуулах үйлчилгээтэй бодисууд
4. Сэтгэцийн хосолмол үйлчилгээтэй буюу дээрх шинж тэмдгүүдийн аль алиныг нь үзүүлэх үйлчилгээтэй бодисууд гэж тус тус ангилна.

## Үүнийг яагаад хэрэглэдэг вэ?

Хүмүүс хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглэдэг хоёр янзын шалтгаан байдаг.

1. Өвчтөнд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд (маш хүнд хагалгаа хорт хавдрын үед гэх мэт) эмчийн хяналтан дор эмнэлгийн нөхцөлд хэрэглэдэг.
2. Эрүүл байгаа тохиолдолд мансууруулах, сэтгэц идэвхит бодисыг хэрэглэх нь хууль бус хэрэглээ гэж үзнэ.

Сүүлийн үеийн судалгаагаар өсвөр насныхан болон залуучууд дараах тохиолдолд

- Хор уршгийг мэдэхгүйгээс
- Бусдад уруу татагдах
- Бусдыг ухамсаргүйгээр дуурайх



- Сонирхож саваагүйтэх
- Сэтгэлийн хямралаас гарах арга гэж үзсэнээс болж хууль бус хэрэглээ өсөж байна гэж үздэг.

### Та ямар эрсдэлд өртөж болзошгүй вэ?

Мансууруулах болон сэтгэц нөлөөт эм бодисыг эмнэлгийн бус зориулалтаар хэрэглэхэд хүний бие болон сэтгэц хордохын зэрэгцээ үүндээ дасаж, тогтмол хэрэглэхийг шаардсан эмгэг хэрэгцээ буюу эрүүл биш дур хүсэлтэй болохыг мансууруулах дон гэж нэрлэнэ.



Мансууруулах бодисын үйлчилгээ нь дуусахад бөөлжис цутгах толгой өвдөх, суулгах гэх мэт шинж тэмдгүүд илрэх ба улмаар даамжирвал бүх бие янгинан өвдөж улмаар ээлжит хэрэглээгээ бие махбодь шаарддаг “шарталт”-ын зовлонд өөрийн эрхгүй гулсан орно.

Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх нь хүний амьдралд нөхөж болшгүй хохирол учруулдаг. Зөвхөн хувь хүний эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд өөрчлөлттэй болж, үр удам, амь насанд аюул учруулах эрсдэл байнга дагалдах төдийгүй, нийгэм эдийн засагт хор хөнөөл учруулдаг.



### **Хор уршиг:**

- Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсноор бэлгийн замаар дамжих халдвар авах
- Зүү тариур дундаа хэрэглэх замаар ДОХ, элэгний халдварт шар өвчнүүдийн халдварыг бусдад тараах, бусдаас авах
- Биеийн өвчин эсэргүүцэх чадвар муудна.
- Оюун ухаан доройтож донтоно.
- Гоо сайхан алдагдана. (арьсны өнгө харлаж, нүүр барзайна, үс унана, хумс хугарна, эрт хөгширнө)
- Бэлгийн сулралд эрт орно.
- Үргүйдэлд эрт орж үр тогтоох чадвар буурна.
- Үр удамд нөлөөлснөөр тахир дутуу, эрхтэн согогтой, ухаан сааталтай хүүхэд төрж болно.
- Байнгын санхүүгийн бэрхшээлтэй байна.

### **Мансууруулах бодисоос хол бай:**

- Түүнийг бүү сонирх бүү хэрэглэ. Бусдын буруу нөлөөнд бүү авт.
- Үгүй гэж зоригтой хэлж сурах нь аливаа эрсдэлд орохоос аварна.
- Хийх гэж байгаа зүйлээ хэрэгтэй эсэхийг сайтар тунгаан бод.
- Тохиолдлын хамгаалалтгүй бэлгийн харьцаанаас ямагт татгалзаж бай.

### **Хэрэв чи мансууруулах бодис хэрэглэдэг бол:**

- Мансууруулах
- Донтох
- Сэтгэлийн гаж хөөрөлд орох
- Гуньж гутрах зэргээр мэдрэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, хараат байдалд орж мансууруулах дон гэдэг өвчин үүснэ.

## **Хараат байдал гэж юу вэ?**

### *Сэтгэл зүйн хараат байдал нь:*

Мансууруулах бодисын хүчээр сэтгэлийн тэнцвэрээ олох хүсэл бий болж, уг бодисын үйлчилгээг дахин дахин мэдрэхийг эрмэлзсэнээр илэрдэг.

### *Бие махбодийн хараат байдал нь:*

Хүний бие мансууруулах бодисгүйгээр хэвийн байж чадахаа байгаад уг бодис л байхгүй бол оршин тогтнох боломжгүй мэт сэтгэгдэл төрөн улам даамжрах явдал юм. Энэ нь махбодь мансууруулах бодисыг нэхэж үгүйлэх байдал юм.

### *Дам хараат байдал:*

Гэр бүлийн амьдралын хэвийн хэмнэл алдагдана. Бие биеэ байнга зэмлэн буруушаасан харьцаа үүснэ. Хараат байдалд орсон гэр бүлийнхэн ажил алба, хүсэл сонирхлоосоо татгалзана. Санхүүгийн байнгын бэрхшээл хямралтай тулгарна.

## **Мансууруулах бодисыг судсаар хэрэглэх нь ямар эрсдэлтэй вэ?**

Мансууруулах бодисыг судсаар хэрэглэх нь хамгийн их аюултай. Судсаар тарьж хэрэглэхдээ зүү тариурыг дундаа хэрэглэвэл бүр ч их аюултай.

Мансууруулах бодис судсаар хэрэглэх үед зүү тариурыг хичнээн угааж цэвэрлэн хэрэглэсэн ч халдвар агуулсан цусны үлдэгдэл заавал үлдсэн байдаг.

- Хар тамхи мансууруулах бодисыг судсаар хэрэглэдэг хүмүүс, зүү тариурыг дундаа хэрэглэсэнээр ДОХ, мөн бэлгийн замын халдвар, элэгний халдварт шар өвчин авна.
- Цусаар дамждаг хамгийн хүнд явцтай В, С хэлбэрийн шар өвчин нь хожим элэгний хорт хавдар болох эрсдэлтэй байдаг.



## БҮҮ ЭХЭЛ:

Хэрвээ та хар тамхи мансууруулах бодисыг:

**Тариалах**

**Боловсруулах**

**Борлуулах**

**Дамжуулах**

**Хадгалах** юм бол Монгол улсын хуулийн дагуу Эрүүгийн хариуцлага хүлээх болно.

*Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист донтох үзэгдлийн нийгэмд аюултай шинж нь тухайн хүн өөрийн сэтгэцийн болон бие бялдрын эрүүл мэндээ хохироогоод зогсохгүй эрүүл саруул байсан хүүхдүүд хэдхэн сарын дотор хүнд өвчтэй болон хувирах, бусдын хүчийг сорж амьдрах амьдралын хэв маяг давамгайлж, нийгэмд аюултай үйлдэл хийхэд хүргэдгээрээ түүний хор уршиг илэрнэ.*

**Мансууруулах бодис бол хүссэн үедээ хэрэглээд, хүсээгүй үедээ хаяж болдог зүйл биш.**

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын мэдээлснээр гурван хүн тутамд нэг хүн хар тамхи мансууруулах бодисын улмаас амь насаа алдаж байна.

Хар тамхинд донтсон өвчтөний эмчилгээний үр дүн дэлхийн хэмжээнд 5%-ийн эдгэрэлтэй байна.

Хар тамхи бол зугаа, цэнгэл болгон сонирхоод өнгөрөх зүйл биш, оюун санаа эрүүл мэнд, санхүүгийн хараат байдалд оруулах хар мөртэй цагаан тахал юм.

Монгол улсын хууль хяналтын байгууллагын шугамаар илрүүлсэн албан ёсны мэдээгээр сүүлийн 10 жилийн хугацаанд энэ төрлийн 388 удаагийн гэмт хэрэгт нийт 1112 хүн холбогдсон байна.

2017 оны 10 сарын 30-ны байдлаар энэ онд 66 гэмт хэрэгт 202 хүн хэрэг бүртгэлийн болон мөрдөн байцаах шатандаа явж байна.


### **Эмэгтэйчүүдэд**

- Мансуурлаас ямар ч үед татгалзаж сур. Мансууруулах бодис хэрэглэх нь жирэмсэн эмэгтэйчүүдийн урагт аюултай.
- Жирэмсэн үед мансууруулах сэтгэц, нөлөөт эм бодисын хэрэглээнд аюулгүй хугацаа гэж үгүй!  
Жирэмсэн үед мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хэрэглээнд аюулгүй хэмжээ гэж үгүй!
- Жирэмсний бүхий л хугацаанд ургийн тархи хөгжиж байдаг тул мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бодис хэрэглэхийг хориглоно!
- Хар тамхины хэрэглээнд  
Аюулгүй хугацаа гэж үгүй  
Аюулгүй хэмжээ гэж үгүй

## **МАНСУУРУУЛАХ БОДИС БА ХДХВ, ДОХ**

### **МАНСУУРУУЛАХ БОДИС**

- Өөрийг чинь дасгаж, үгүйлэн байж яддаг болгож, та түүний боол болно.
- Сургууль гэр бүлд чинь хэрүүл маргаан үүсгэж, та дотны найз нөхдөөсөө салах болно.
- Сэтгэл зүйд тань нөлөөлж, та өөрийгөө удирдан чиглүүлэх чадваргүй болно.
- Хэтрүүлэн хэрэглэвэл та амь насаа алдах болно.

- 
- Хэрэглэснээрээ та орчин тойрондоо аюул учруулж, хуультай тэрсэлдэх болно.
  - Таны эрүүл мэндэд нөхөж баршгүй хор хөнөөл учруулна.

### **ХДХВ-ийн халдвар**

ХДХВ нь хүний биеийг аливаа халдвар, хорт хавдраас хамгаалдаг дархлалын эсүүдийг гэмтээж янз бүрийн өвчин эмгэгт өртөмтгий болгоно.

ХДХВ-ын халдвар авснаас хойш ДОХ-ийн өвчлөл илрэх хүртэл дунджаар 5-12 жил өнгөрдөг тул тухайн хүн халдвар авснаа мэдэхгүй бусдад тараах аюултай. Тухайн хүн халдвар авсан болохыг зөвхөн шинжилгээгээр тогтооно.

Мансууруулах бодис хэрэглэгч хүн ХДХВ-ээр халдварлагдсан бол амьдралынх нь үргэлжлэх хугацаа 2-3 дахин богиносно.

### **ХДХВ-ын халдварлах замууд**

Мансууруулах бодисыг судсаар тарьж хэрэглэх явдал сүүлийн 10 жилд эрс нэмэгдэж дэлхийн 136 оронд бүртгэгдсэн байна. Мансууруулах бодисын судсаар тарьж хэрэглэгчдийн 10-20% нь ХДХВ-ын халдварт өртөж байна.

- Хамгаалалтгүй бэлгийн харьцаанд орох( бэлгэвчгүй)
- Халдварлагдсан зүү тариур хэрэглэх, халдварлагдсан багажаар шивээс хийлгэх, халдварлагдсан хүний цус тогтсон шүдний сойз, сахлын хутга хэрэглэх гэх мэт.
- ХДХВ-ын халдвар авсан жирэмсэн эхээс урагт, нярай хүүхдэд хөхний сүүгээр дамжин халдварлах боломжтой.

## **ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛ**

Мансууруулах бодис битгий хэрэглээрэй.

Бүх насаараа зовж байхаар нэг удаа татгалзах нь амар шүү дээ.

Тохиолдлын бэлгийн хавьталд бүү ор.

Бэлгэвчийг байнга зөв хэрэглэ.

Нэг удаагийн ариун зүү тариур хэрэглэ.

## **ХАР ТАМХИ МАНСУУРУУЛАХ БОДИСООС ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ**

1. Судалгаа хийнэ.
2. Зан үйлийг өөрчлөх сургалт явуулна.
3. Сэтгэл зүйн зөвөлгөө өгнө.
4. Үнэгүй тариураар үйлчилнэ.
5. Үнэ төлбөргүйгээр бэлгэвч өгдөг.

Хаяг: ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ-1,  
2-р 40000-тын 38-34 тоот  
УЛААНБААТАР -23, Ш/Х-88

Утас: /976/ 70115703 /ажлын/  
ГАР УТАС: /976/ 9919 9228, 99293076

И-МЭЙЛ: shkhagvasuren 2014@yahoo.com  
APPDOmongolia@gmail.com



Төрийн бус байгууллага

БЗД 18-р хороо “Шинэ зуун” хотхон

24г-22 тоот

Улаанбаатар хот, Монгол улс

Утас:77055390

[www.tugsbu busguichuud.mn](http://www.tugsbu busguichuud.mn)

*Багцыг боловсруулсан: Ш.Лхагвасүрэн*

*Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Чулуунбат*

ЭМЯ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүгийн  
дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.